

みんなのデジタルリポジトリ

国立民族学博物館 学術情報リポジトリ National Museum of Ethnology

Мелитина Ивановна

Клягина-Кондратьева :

намтар, шинжлэх ухааны йлс

メタデータ	言語: eng 出版者: 公開日: 2018-03-09 キーワード (Ja): キーワード (En): 作成者: S. , Чоローン, Т.И., Юсупова メールアドレス: 所属:
URL	https://doi.org/10.15021/00008891

Мелитина Ивановна Клягина-Кондратьева: *намтар, шинжлэх ухааны үйлс*

1926–1930 онд Монголын судар бичгийн хүрээлэнд ажиллаж байхдаа Мелитина Ивановна Клягина-Кондратьева (*хадамд гарахаас өмнөх овог нь Кляшина, 1896–1971*) «Монголын буддын сүм хийдүүдийн судалгааны материал» бүтээлээ туурвисан нь хожим Оросын нэрт монголч эрдэмтэн К.Н.Яцковская түүний монголд бичсэн тэмдэглэлүүдийг нийтлүүлсний ачаар олны хүртээл болсон байна¹⁾.

Мелитина Ивановна Орловын помещикийнд төржээ. Тэрээр 1920–оод онд Москвагийн Дорно Дахин судлалын дээд сургуульд суралцан дорно дахин судлаач – энэтхэгч мэргэжлээр төгсөөд Москвад Оросын Нийтийн номын санд (1925 оноос В.И.Лениний нэрэмжит номын санд) ажиллаж байв. Мелитина Ивановна англи, хинди, урду, санскрит зэрэг 14 хэл мэддэг байжээ. Мелитина оюутан байхдаа мөн дээд сургуульд сурч байсан оюутан Сергей Александрович Кондратьевтай (1896–1970) танилцаад 1923 оны эхээр түүний гэргий болжээ²⁾. С.А.Кондратьев тэр жилийн зун П.К.Козловын 1923–1926 оны Монгол-Түвэдийн экспедицэд ороод Монгол руу явжээ. Кондратьев тус экспедицэд ажиллах хугацаандаа Ноён уулын Хүннүгийн булшны малтлагад маш чухал үүрэг гүйцэтгэж байв. С.А.Кондратьев 1925 онд Жамсраны Цэвээний саналын дагуу Монголын судар бичгийн хүрээлэнгийн ажилтан болоод 1930 он хүртэл ажиллажээ.

Мөн тэр Жамсраны Цэвээний урилгаар 1926 онд ЗСБНХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөлтийн харьяаны Монголын Комисс М.И.Клягина-Кондратьеваг Улаанбаатар руу томилон илгээжээ. Мелитина энд ирээд нөхөртэйгээ адилхан Судар бичгийн хүрээлэнд ажиллажээ. Тэгэхдээ тус хүрээлэнгийн Европ номын фондын эрхлэгч болоод тэр фондын номыг эмхлэн цэгцлэх, каталогжуулах их ажил хийжээ.

Мелитина тэмдэглэлийнхээ дэвтэрт Судар бичгийн хүрээлэнд 1929 оны арван нэгдүгээр сарын нэгэн өдөр хэрхэн ажилласан тухайгаа ингэж бичсэн байна:

«Төрсөн үр шигээ хайрлах болсон номын сандаа ирэхдээ би их баяртай байдаг. Номын сангийн зүүн талын үүд нь дорно дахины номын хэсэг, баруун талын үүд нь Европ номын хэсэг байв. Зүүн үүдээр цоожийг нь тайлаад ороход минь чөтгөр ч тогтохын аргагүй хүйтэн байв. Миний араас үргэлж боолттой хацартай явдаг өвөгжөөр монгол галч орж ирээд гал түллээ. Удалгүй дулаан болж дээлээ тайлахад хүрлээ. Дээлээ нөмрөөд бөөн бөөн номуудаа бахархан харж зогслоо. Эмх цэгцгүй овоолоостой байсан номуудыг журамлан, номын сангийн дүрэм журмын дагуу

шүүгээ тавиуруудад өрж тавьж байлаа. Ленины номын санд арван жил ажилласан туршлага минь надад их хэрэг болж билээ. Хийж бүтээснээ харахад бахархах сэтгэл төрнө. Номын сангийн тамга тэмдэг, дугаар бүхий номууд шүүгээний тавиур дээгүүр ярайн эгнэх нь сэтгэлд таатай. Тэгж эмхлэн цэгцлэж, бүртгэл дугаар тавиад зохих газруудад нь тавих номнууд ч бас олон байна. Энэ ажлаа нэгдүгээр сарын нэгнээс өмнө дуусгах санаатай яарч байхад хажуугаар нь уншигчдаас номны захиалга авах, ном олгох ажил давхцана. Гэхдээ ном авч уншдаг хүн тийм олон байгаагүй нь яамай. Саяхан хэдэн ном худалдаж авсан түүнийг янзлах хэрэгтэй. Тун идвэхтэй чармайлттай ажиллаж байв. Зүүн талын цонхоор харахад уулс цастай харагдаж байна. Өмнө талын цонхоор сүрлэг сайхан Богд уул харагдана. Өнөөдөр тэнгэр цэлмэг, цэв цэнхэр. Хүмүүс орж ирэх нь ховор хааяа Нина Павловна (Шастина) авсан номоо буцааж өгөөд шинээр ном авахаар ирэхдээ ойр холын хов дуулгана. Будда бурхны хөргөөс бууж ирэв үү гэлтэй сайхан эр Ринчен ирж Дорно дахины хэсгийн номуудыг бүртгэх цаашлаад зөвлөж ярилцана. Ухаалаг залуу Эрдэм-Баяр орж ирээд гар бичмэлүүдийн бүртгэл хийж хоёр гурван цаг сууна. Өнөөдөр тайж угтай ганган хээнцэр юм юманд авхаалжтай сэргэлэн Гомбожав орж ирээд Парист сууж байсан тухайгаа ярьлаа. Тэнд гурван жил болохдоо франц хэлийг гаргууд сайн сурчээ. Өдөрт ганц хоёроос олон хүн орж ирнэ гэж бараг байхгүй. Хүн ирэхгүй өдөр ч байна. Гэвч надад уйтгартай санагддаггүй. Би номд дуртай учраас энд ажиллахдаа баяртай байдаг. Одоо хоёр цаг болох гэж байна. Өдрийн ажлаа дүгнэн хүснэгт байсан дэвтэртээ ном бүртгэж, хэдэн номны католог бичсэнээ хэдэн уншигчдад ном олгосон, хэдэн ном хүлээж авснаа цөмийг тэмдэглэх хэрэгтэй. Мөн бусад ажлаа ч бүртгэх хэрэгтэй. Тэр бүхнийгээ сарын эцэст нэгтгээд тайлан гаргана. Жилийн тайлан гэж бас байна. Ажил урагштай байна, нэгдүгээр сарын нэгэн гэхэд ажлаа дуусгаж төлөвлөгөө биелүүлэх найдвар байна. Гэртээ аваачаад зохих тэмдэглэл хийхээр хэдэн ном аваад гарлаа (эс тэгвэл амжихгүй байж мэднэ). Номын сангийнхаа үүдийг цоожлоод гэр рүүгээ алхлаа»³⁾ гэж бичиж байжээ.

Мелитина Ивановна нөхрийнхөө шинжилгээ судалгааны ажилд их тусалдаг, түүнтэй хамт экспедицээр явж ургамал шавьжийн цуглуулга хийдэг, цаг уурын ажиглалт хийдэг байв. Монгол оронтой сайтар танилцсаны ачаар түүний түүх, орон нутгийн уран барилгыг шимтэн судлах болжээ. Мелитина сүм хийдийн уран барилгыг даамай судлах болсон шалтгаанаа Монгол орны амьдралыг судалдаг хэн ч гэсэн сүм хийдийг анзаарахгүй өнгөрөхгүй нь лавтай, яагаад гэвэл сүм хийдүүд шашны төдийгүй материаллаг соёлын төв байх утга учраа одоо болтол алдаагүй байгаа юм хэмээн тайлбарладаг. Мелитина экспедицэд оролцож явах болгонд том, бага сүм хийдүүдтэй сайтар танилцдаг, тэдгээрийн онцлог талуудын тухай тэмдэглэл хөтөлдөг, сүм дугануудын байрлал дэвсгэр зургийг зурж авдаг, нөхөртөө хэлж хамгийн сонин содон дуган сүмүүдийн гэрэл зургийг авахуулдаг байв⁴⁾. Клягина Кондратьева экспедициэр аялан явсан тухайгаа өдрийн тэмдэглэлдээ тодорхой бичдэг, түүнд орсон хийдүүдийн болон тэнд уулзсан лам нарын гэрэл зургуудыг хавсаргадаг байжээ.

Богино хугацаанд ч гэсэн сүм хийдүүдийг судалсны үр дүнд миний бие «Брэвэн хийд» гэдэг найруулал, «Монголын буддын сүм хийдийг судалсан эх хэрэглэгдэхүүн» хэмээх тайлан бичээд 1923 онд “*Гадаад Монголын гэр хэлбэрийн уран барилгуудын тухай*”⁵⁾ гэдэг өгүүлэлтэйгээ хамт ЗСБНХУ-ын Шинжлэх Ухааны Академид явууллаа гэж Мелитина тэмдэглэлдээ бичсэн байдаг. «*Хүн амын олонхи нь нүүдлийн аж байдалтай оронд уран барилга үүсэн хөгжиж чадах уу?*» гэдэг асуултад Мелитина дээрх нийтлэлүүдээрээ хариулахыг оролджээ. Тэгээд үзсэн харсан барилга байгууламжинд нарийвчилсан дүн шинжилгээ хийгээд «*Монголд үндэсний уран барилга байгааг нотлоход хүрэлцээтэй баримт материал байна*» гэж би бодож байна. Тэр өвөрмөц уран барилгын тухай дорно дахины уран барилгын түүхэнд зохих ёсоор одоо болтол тусгагдаагүй нь үнэн. Уран барилгын энэ хэв шинжийг нутаг дэвсгэр угсаатны хэв шинжээр монголын буюу эсгий гэр маягийн гэж нэрлэж болох бүрэн боломжтой»⁶⁾ гэжээ.

Кондратьевынх 1930 онд Орос орондоо буцаж очоод Москвад суурьшижээ. Мелитина Ивановна англи хэлний орчуулагчаар ажиллах хугацаандаа уран зохиолын ном олныг орчуулахын зэрэгцээгээр хөгжим их сонирхдог байв. С.А.Кондратьев Монголд байхдаа эхэлсэн хөгжмийн үйл ажиллагаагаа Москвагийн театруудад үргэлжлүүлж бас эх орноороо их аялан явж байгалийн тухай олон өгүүлэл, ном бичиж нийтлүүлжээ. Кондратьев насныхаа эцэст Монголоос цуглуулсан материлаа эмхэлж цэгцлээд «Монголын туульс ба дууны хөгжим» гэдэг ганц сэдэвт зохиол бичсэн нь түүний нас барсны дараа 1970 онд нийтлэгджээ. Мелитина Ивановна энхрий хайрт нөхрөөсөө хойш удалгүй 1971 оны хоёрдугаар сарын 4-нд нас баржээ. С.А. ба М.И. хоёр Кондратьевыг Санкт-Петербургийн Пулковскийн дэнж дээрх Кондратьевуудын нэрэмжит оршуулгын газарт тавьжээ⁷⁾.

Мелитина Ивановнагийн 1929 оны хоёрдугаар сарын 5-нд бичсэн «Монголын сүм хийдүүдийг судалсан эх хэрэглэгдэхүүн. *Хэнтий, Хангайн хийдүүдийн шүтээн тахилын ба орон сууцны барилгыг тодорхойлох оролдлого*» байсан Оросын Шинжлэх Ухааны Академийн Архивын Санкт-Петербургийн салбарт академич Ф.И.Щербатскийн фондод хадгалагдаж байгаа ажээ⁸⁾. Машинаар цохисон 72 хуудастай тэр тайланд сүм дугануудын 75 гэрэл зураг хавсаргажээ. Тэдгээр гэрэл зургийг Монголын Судар бичгийн хүрээлэнгээс 1926, 1927, 1928 онуудад зохион байгуулсан гурван удаагийн экспедицийн явцад С.А.Кондратьев (58 зураг), А.Д.Симуков (7 зураг) нарын авсан зураг юм. Мөн тэнд Хүрээлэнгийн ажилтан Ф.Ф.Большаковын зурсан дөрвөн ширхэг топографийн план зургийг хавсаргажээ.

Мелитина Ивановнаг Улаанбаатар руу томилж явуулсан Монголын комисс ЗСБНХУ-ны Шинжлэх Ухааны Академид шилжсэн учраас Мелитина тайлангаа ШУА-д илгээсэн юмсанжээ. Энэ өгүүлэл бол эрдэм шинжилгээний бүтээл бус

Монголын сүм хийдийн судалгаанд миний зүгээс оруулсан тайлан төдий юм гэж зохиогч өөрөө бичсэн байдаг⁹⁾. Оросын эрдэмтдийн Монголд хийж байсан энэ талын судалгааг ЗСБНХУ-ын ШУК-ийн байнгын эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1927–1929 онд Монголын комиссын дарга байсан академич С.Ф.Ольденбург (1863–1934) ихээхэн дэмждэг байв. Дээрх тайланг Монголын комисс Буддизм судлалын нэрт эрдэмтэн Ф.И.Щербатскийд шилжүүлэн өгсөн учраас түүний фондод хадгалагдаж байгаа бололтой. Тайлангийн хуулбарыг Монголын Судар бичгийн хүрээлэнд өгчээ. М.И.Клягина-Кондратьева ажлын явцад цуглуулан цэгцэлсэн материалаа түүхийн талаас нь өгүүлэхийг оролдоогүй, байгаа байдлаар нь баримт болгон үзүүлэхийг хичээсэн учраас уншигч нар түүнийг нь өөрийн үзэмжээр үнэлэн дүгнэх боломжтой ажээ.

М.И.Клягина-Кондратьевагийн материал бол 2009 онд хэвлэгдсэн «Монголын сүм хийдийн түүх» тулгуур бүтээлийн (Улаанбаатар, 2009) чухал нэмэлт Монголын түүх, соёлын судалгаанд Оросын судлаачдын оруулсан бас нэг хувь нэмэр мөн хэмээн бид үзэж байна.

М.И. Клягина-Кондратьевагийн “Монгол дахь бурханы шашны сүм хийдийн судалгааны эх хэрэглэгдэхүүнүүд...” гар бичмэлийг товчлож хураангуйлалгүй тэр хэвээр нь орчин үеийн бичвэрт оруулан зохиогчийн бичлэгийн онцлогийг хадгалан хэвлүүлж байна. Зарим хэсэгчилсэн үг өгүүлбэр зэргийг хашилтад хийх эсвэл тодорхойлон оруулсан юм. Жишээлбэл кк-как, оч.-очень гэх мэтээр.

С.Чулуун, Т.И.Юсупова

Примечания

- 1) Из воспоминаний М.И. Клягиной-Кондратьевой / публикация К.Н. Яцковской // *Mongolica* – VII. СПб., 2007. С. 93 – 94; *Клягина-Кондратьева М.И.* Дневниковые записи. Хангайская экспедиция 1928 г. / публ. и прим. К.Н. Яцковской // *Mongolica* - V. СПб., 2001. С. 125 – 156; *Клягина-Кондратьева М.И.* 1–я Кентейская (Ононская экспедиция) / публ. и прим. К.Н. Яцковской // *Российское монголоведение.* Бюллетень. IV. М., 1996. С. 125–142; *Клягина-Кондратьева М.И.* Гобийская экспедиция 1929 / публ. и прим. К.Н. Яцковской // *Российское монголоведение.* Бюллетень V. М., 1996. С. 412–435.
- 2) Жизнь и научная деятельность С.А. Кондратьева (1896 – 1970) в Монголии и России / ред.-сост. И.В. Кульганек и В.Ю. Жуков. СПб., 2006.
- 3) Из воспоминаний М.И. Клягиной-Кондратьевой / публикация К.Н. Яцковской // *Mongolica* – VII. СПб., 2007. С. 93 – 94.
- 4) Из воспоминаний М.И. Клягиной-Кондратьевой / публикация К.Н. Яцковской // *Mongolica* – VII. СПб., 2007. С. 98.
- 5) Советская этнография. 1935. № 3. С.14 – 41.
- 6) Советская этнография. 1935. № 3. С. 39.

- 7) Жизнь и научная деятельность С.А. Кондратьева (1896 – 1970) в Монголии и России / ред.-сост. И.В. Кульганек и В.Ю. Жуков. СПб., 2006. С. 29 – 30.
- 8) СПФА РАН. Ф. 725. Оп.4. Д. 29.
- 9) СПФА РАН. Ф. 725. Оп.4. Д. 29. Л.1.